



НИЙСЛЭЛИЙН НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 4/24

Улаанбаатар хот

Ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгох
журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам батлах тухай Монгол улсын Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, Нийгмийн хамгааллын тусгай төвийн даргын дэргэдэх зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Төвийн ажилтнуудын ажлын үр дүнг харгалзан сар бүр ур чадварын нэмэгдэл олгосугай.
2. Ур Чадварын нэмэгдэл олгох журмыг хавсралтаар баталсугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажилтнуудад нээлттэй мэдээлж ажиллахыг Дотоод хяналтын зөвлөл / ахлах арга зүйч Н.Нэргүй/-д даалгасугай.

ДАРГА



ГЦЭРЭНДУЛАМ

318060538

Нийгмийн хамгааллын тусгай төвийн даргын 2022 оны 01 сарын 20-ны өдрийн 109 дугаартай тушаалын хавсралт



АЖИЛТНУУДАД АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын дүрмээр хүлээсэн үүрэг болон байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, албан хаагчдын ажлын хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх, ажлыг үрдүнг бодитой үнэлэх, албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад оршино.

Хоёр. Ажилтан, албан хаагчийн ажил дүгнэх

2.1 Ажилтан албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг тооцон олгоходоо шударга ил тод зарчмыг баримтлан ажлын үр дүнг улирал тутам дүгнэж сар бүр олгоно.

2.2 Ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингийн 10-25 хувиар тооцож олгоно.

2.3 Ажилтнуудыг дүгнэсэн үнэлгээг Дотоод хяналт хариуцсан ажилтан нэгтгэж Төвийн даргын дэргэдэх зөвлөлд танилцуулан баталгаажуулна.

Гурав. Ур чадварын нэмэгдэл олгох

3.1 Эрхэлсэн ажлаа мэргэжлийн түвшинд гүйцэтгэж байгууллагын зорилго, зорилтыг биелүүлэхэд идэвх санаачлага гаргаж, өгсөн үүрэг даалгаврыг хугацаандаа биелүүлсэн, багаар ажиллах чадвар, өөрийгөө тасралтгүй хөгжүүлсэн байдал, олон нийтийн ажлын оролцоо зэргийг харгалзан ур чадварын нэмэгдлийг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж олгоно.

Ажил дүгнэх шалгуур үзүүлэлтийн хүснэгт

д/д	Шалгуур үзүүлэлт	Авбал зохих оноо
1	Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	/0-60 оноо/
2	Ажлын цаг ашиглалт	/0-15 оноо/
3	Цаг үеийн ажил	/0-5 оноо/
4	Шинээр санаачлан хийсэн ажил үйлчилгээ, багаар ажиллах чадвар	/0-15 оноо/
5	Мэдлэг чадвараа дээшлүүлж буй байдал	/0-5 оноо/
	Нийт	100 оноо

Ур чадварын нэмэгдлийн хувь

	Оноо	Хувь
1	90	10%
2	91	11%
3	92	12%
4	93	13%
5	94	14%
6	95	15%
7	96	16%
8	97	17%
9	98	18%
10	99	19%
11	100	20%
12	Онцгой ур чадвар гаргаж ажилласан бол	Үнэлгээний оноон дээр 5% нэмэх

3.2 Ур чадварын нэмэгдлийг зөвхөн тухайн албан тушаалыг эрхэлж буй хугацаанд, ажилласан цагт ногдох цалингаас тооцож сар тутам олгоно.

3.3 Ажилтан тухайн сарын ажлын хоногийн 85%-д бүтэн ажилласан тохиолдолд ур чадварын нэмэгдэл олгогдох эрх үүснэ.

Дөрөв. Ур чадварын нэмэгдэл олгохгүй байх үндэслэл

4.1. Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, төвийн даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан бол шийтгэлтэй байх хугацаанд.

4.2. Тухайн ажилтны ээлжийн амралтаа эдэлж буй сард.

4.3. Цаг үеийн шинжтэй удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлээгүй тохиолдолд.

4.4 Туршилтын болон түр хугацаагаар ажиллаж байгаа ажилтанд.

4.5 "Ёс зүйн дүрэм"ийг зөрчсөн тохиолдолд.

Тав. Мөрдөж эхлэх хугацаа

5.1 Энэхүү журмыг Төвийн даргын тушаалаар баталсан өдрөөс эхлэн мөрдөнө.